

Д.МӨНХТӨР

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологич

ПОСТ МОДЕРН СОЁЛЫН НӨХЦӨЛ ДЭХ НҮҮДЭЛЧИД: ШИНЭ ЭРСДЭЛ ҮҮ ЭСХҮЛ ШИНЭ БОЛОМЖ УУ?

Abstract: *This paper aims to analyze the process and trends of existence of the nomadic way of life in compliance with social changes basing on the case of Mongolian nomads. It might be worth noting that by mentioning trend the author didn't intend to make prediction basing on historical one linear concept or progress concept of modernization.*

The author considers that social changes in the border of 20th and 21st century brought a favorable period especially for Mongolian nomadism as a way of life.

Key words: *Nomadism, Mobile Pastoralism, Nomads, Herder, Nomadic Way of Life, Moderisation, Postmodern culture, Social Change*

Энэхүү ажилд нүүдэллэн аж төрөх ёсны оршихуйн явц, чиг хандлагыг нийгмийн өөрчлөлт хувирлын үйл явцтай уялдуулан Монголын нүүдэлчдийн жишээн дээр шинжлэхийг зорилгоо. Харин чиг хандлага гэхдээ түүхийн нэг шугамт, эль эсхүл модернжилтийн дэвшлийн үзэл баримтлалын дагуу төлөгчлөл хийхийг оролдоогүй гэдгээ тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Монголын нүүдэлчид¹³⁹ бол аль ч талаасаа (түүхэн талаасаа ч тэр, экологийн аль эсхүл эдийн засгийн талаасаа ч тэр) Евразийн хэв маягийн нүүдэллэн аж төрөхүйн хамгийн цэвэр, хамгийн тод жишээнд татагдаж болох хэв маяг бөгөөд бэлчээрийн мал аж ахуй нь нүүдэлчдийн хувьд зөвхөн амьжиргаа залгуулах арга зам төдийгүй тэдний өөрсдийнх нь өвөрмөц аж төрөх ёсны үндэс юм.

Нүүдэлчин гэгдэх аж ахуй эрхлэлт хийгээд соёлын үндсийг бүрдүүлэгч нийгмийн бүлэг нь – үндсэндээ бүтэн жилийн турш бэлчээр хөөн малаа малладаг, амьжиргаа нь ч энэхүү нүүдлийн аж төрөх ёстойгоо уялдсан бөгөөд газар тариалан ба бусад орлогын эх үүсвэр болж болох ажлыг гагцхүү нэмэгдэл болоод хавсарга шинж бүхий үйл ажиллагаа болгон эрхэлдэг, эсхүл огт эрхэлдэггүй бүлэг болон хүмүүс юм. Харин нүүдэллэн аж төрөх ёс хэмээх нь зөвхөн мал маллан аж төрөх бүлэг хүмүүсээр хязгаарлагдах ойлголт биш гэдгийг тэмдэглэе.

Казанов, суурин амьдрал руу эрмэлзэн тэмүүлдэггүй агнуурчин ба олзворлогчид “хэрмэл” (Wandering) хэмээх нэр томъёогоор, уудам нутаг бэлчээрийг хамран байршлаа солих малчид болохоор “нүүдэлчин” (Nomad) хэмээх нэр томъёогоор хангалттай тодорхойлогдож болохыг тэмдэглэжээ.

Нүүдэлчдийн түрэлтийн эрин

Нүүдэлчид нь өнгөрсөн үед дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүргээсээ болоод түүхчдийн анхаарлыг хамгийн ихээр татсан нийгэм байсны сацуу өөрийн гэсэн өвөрмөц аж төрөх ёсныхоо улмаас социал антропологичдын анхаарлыг багагүй татаж байсан юм. Зарим судлаачийн үздэгээр (Giddens, 1994:19) орчин үеийн аж үйлдвэржсэн нийгэм дэх институцүүдийг илүү судлах ёстой нийгмийн ухааны салбар гэгддэг социологи ч гэсэн энэ асуудлаас хол хөндий байсангүй.

¹³⁹ Энэхүү ажилд Монголын нүүдэлчид нэрийн дор дурьдагдан буй бэлчээрийн мал аж ахуй эрхлэгсэд нь улс орны дотоодын нийт бүтээгдхүүний 10 хүрэхгүй хувийг үйлдвэрлэж буй бөгөөд 2010 оны байдлаар Монголын нийт өрхийн 21.6 хувийг бүрдүүлж байгаа болно. Мөн уг ажлын хүрээнд нүүдэлчид (nomads) хэмээх нэр томъёоны талаар нарийвчилсан мэтгэлцээн хийхийг зорилго болгосонгүй. Энэ талаар А.Казанов(1994), Кэролин Хамфри, Дэвид Снит(1999) нарын бүтээлүүдэд хийгдсэн шинжилгээг үзэж болно.

Бүр XIV зуунд, социологийн сонгодогуудтай зарим талаараа дүйцэхүйц хэмжээний шинжилгээ хийж байсан гэддэг Арабын сэтгэгч Ибн – Халдун (1997: 302 - 304) “Мукаддима” хэмээх бүтээлдээ нийгмийн хэв маягийн ангилал хийж, нүүдлийн хөдөөгийн амьдрал ба суурин хотын амьдрал гэсэн хоёр төрлийн нийгэмд өөр өөрсдийнх нь онцлогийн үүднээс шинжилгээ хийж байв.

Гроуссет (Grousset, 1939)-аас Сэзер (Sezer, 1979:106)-ийн иш татсанаас үзвэл нүүдлийн ба суурин нийгмүүдийн харилцааг дараахь 2 үе шатад хуваан үздэг байна.

1. Нум сумаар зэвсэглэсэн морьт цэргийнхээ хүчээр тогтоосон талын нүүдэлчдийн цэргийн давуу тал
2. XVI зуунаас галт зэвсэг гарч ирсэнтэй холбоотойгоор суурин нийгмүүдийн тогтоосон цэргийн давуу тал

Үнэхээр ч XVI зуунаас өмнөх дэлхийн түүх нүүдэлчдийн, тэр дундаа Хүн гүрэн, Түрэг ба Монголын нүүдэлчдийн тааварлахын эрхгүй бөгөөд сөрж зогсоход бэрх түрэлтүүдээр дүүрэн. Эдгээр нь, тухайлбал Данилевскийн хувьд (Sorokin, 1997: 80 - 81), нарны системийн дотор, гараг эрхсүүдийн зэрэгцээгээр үе үе гялсхийн үзэгдсэнээ дараа нь ахиад л хэдэн зуун жилээр сансар огторгуйн гүн рүү уусан алдарч сураггүй болдог сүүлт одос мэтээр хүн төрөлхтний орчилд байсхийгээл гялалзан тодроод сөнөн үгүй болдог түр зуурын хүчин зүйлс буюу зүйрлэвээс, амь тавьж буй иргэншлүүдэд Тэнгэрийн ташуурын үүргийг орлодог хар хүч бүхий эвдлэн сүйтгэгч ард түмэн, овог аймгууд хэмээн тооцогддог бол, зарим судлаачид тэднийг суурин төр улс болоод иргэншлүүдийн хоорондох хэлхээ харилцаанд холбон зуучлагчийн үүргийг үе үе гайхалтай ихээр гүйцэтгэсэн бүлгүүд (Hall, 1991: 34 - 35) хэмээн үздэг байна. Тухайлбал, Абу – Лухад (1989) –ын хэлснээр бол Монголын эзэнт гүрэн XIII зуунд Евразийн дэлхийн системийн сүйрэлтэд, үүнээс улбаатай Европын дэлхийн систем үүсэн гарч ирэх үйл явцад голлох үүргийг гүйцэтгэжээ.

“Монголчуудын байлдан дагуулалтын үе, тэр тусмаа XIII ба XIV зуун бол Ази тивийн хувьд хамгийн чухал түүхэн цаг үеийнх нь нэг юм. Харин энэхүү цаг үеийн нөлөө нь гагцхүү Ази тивийн хилээр хязгаарлагдаагүй бөгөөд Ази, Европ хэмээх хоёр хөгшин тив чухамхүү тэр цаг үед л жинхэнээсээ нүүр тулан биесээ мэдэлцэх болсон юм. Дотоод Ази ба Дорнод Европын улс төр, угсаатны төрх байдал энэ л цаг үеийн үйл явдлуудын нөлөөн дор бүрэлдэн тогтсон агаад түүнээс хойш юу ч болсон байлаа гэсэн гагцхүү тэр өнгөрсөн үйл явдлуудын гарцаагүй үр дагавар болой.” (Ligeti, 1997 а: 33)

Модернжилт хийгээд нүүдэлчид

Харин модернжилтын түрүү үеэр тээвэрлэлт хийгээд цэрэг дайны хэрэгт суурин төр улсуудын бий болгосон чухал ололтуудын үр дүнд дээрх нөхцөл байдал өөрчлөгдөж эхэлсэн байна. Энэ цаг үеэс эхлэн, нүүдэлчид юун түрүүн цэргийн давуу байдлаа, араас нь мөн төр улсын тусгаар байдлаа алдсан бөгөөд эцэс сүүлд нь өөрсдийн хяналтаас гадуур хүчнүүдэд (орчин үеийн ба шинэчлэгдэж буй суурин ертөнцийн эдийн засаг ч үүнд хамаарна) дасан зохицохоос аргагүй байдалд оров.

Малчид нүүдэлчид эхлээд колоничлогч хүчнүүд, дараагаар нь газар тариалан ба аж үйлдвэрийг тэргүүлэх чиглэл болгон, нүүдэлчдийн эсрэг бодлогыг няхуур хэрэгжүүлсэн засаг төрүүдийн эрхшээлд орсон нь олон талын хортой нөлөөлөл авчирсан юм. Энэ нөхцөл байдал нь нүүдэлчдийг улам л маригинал /голлох биш, захын/ шинжтэй болгож, эзэмшил газар нутгийг нь багасгаж, амьжиргаа залгуулах чиглэл бүхий эдийн засгийг нь сульдүүлсан бөгөөд нийгмийн тогтвортой байдлыг нь ч ягуухнаар алдагдуулсан байна.

Би энд модернжилтийн явцад, орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололтын үр шимийг нийгмийн бусад бүлгүүдийн адил нүүдэлч малчид ч хангалттай хүртэж, соёлжиж боловсорч байсныг тэмдэглэхийн зэрэгцээгээр энэхүү ажлын үндсэн сэдэв биш учраас дэлгэрүүлэлгүй орхиж буйг минь анхааралдаа авахыг хүсэж байна.

Өнөөгийн дэлхий ертөнцөд өнгөрсөн цаг үеүүдэд байсан шиг нүүдэлчдийн төр улсууд хэмээх үзэгдэл нэгэнт үгүй болжээ. Түүний оронд харин, суурин хотожсон ертөнцийн орчин үеийн эдийн засаг ба улс төрийн тогтолцоон дотор шууд болоод дам байдлаар хэдийнээ татагдан орсон, аль нэгэн үндэсний төр улсын (nation-state) иргэний статустай, өөрсдийн гэсэн өвөрмөц аж төрөх ёс, амьдралын хэв маяг бүхий бүлэг эсхүл бүлүүдийн тухайд л асуудал яригдах болж байна. Тэгээд ч цагтаа Вебэрийн бичиж байсанчлан, орчин үеийн иргэншсэн

ертөнцийн дийлэнх хэсэгт хотын социал бүлүүдээс бүрэн ангид тийм хөдөөгийн нийгэм гэж угаасаа үлдсэнгүй. (Weber, 1993: 298)

Өнөөгийн дэлхий ертөнц дэх нүүдэлчдийн хувь тавилан хийгээд нүүдэллэн аж төрөх ёсны талаар судлаачдын дунд янз бүрийн үзэл бодол байдаг. Тухайлбал, Казановын(1998: 7) бодлоор бол,

“Тэдний өнгөрсөн нь -хэрвээ дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн хуучин үүргийг нь бодолцвол- нэгэн цул, өнөөдөр нь тогтвортой бус, оршин буй чиг хандлага хэвээр үргэлжлэх юм бол ирээдүй нь одоохондоо тодорхой бус” аж.

Басхүү зарим судлаачид нүүдэллэн аж төрөх ёсыг дасан зохицохуй ба тэсэж үлдэхүйн хамгийн шилдэг арга (Lancaster and Lancaster, 1998: 33) хэмээн (нүүдэлчдийн өөрсдийнх нь хувьд - Д.М) тайлбарладаг бол, бэлчээрийн нүүдэллэхүйг хувьслын хувьд замынхаа төгсгөлд ирсэн (evolutionary-dead-end) болохыг нь тэмдэглэгсэд ч байна. (Шнирельман, 1986: 244; Крадин, 1992: 191)

Үнэхээр ч цөөдөхөөргүй тооны засаг төрүүд болоод төрийн зүтгэлтнүүдийн зүгээс, ялангуяа хуучны социалист болон Гурав дахь ертөнцийн орнуудад нүүдэллэн аж төрөх ёс үл хайхрагдаж байсан нь, одоо ч энэ байдал зарим улс оронд байсаар байгаа нь үнэн юм. Тэд нүүдэллэн аж төрөхүйг, цаг нь өнгөрсөн, үр өгөөжгүй эдийн засаг хэмээн тооцсон бөгөөд үүнээс илүү аюултай нь гэвэл, нүүдэллэн аж төрөхүйг хөгжил дэвшлийн замд, модернжилтийн зэмд учирсан сааад тээг хэмээн албан ёсоор зарласан явдал байлаа. Чухамхүү үүнээс улбаатайгаар нүүдэлчид эзэмшлийн нутаг бэлчээрээ алдах, тэр ч бүү хэл өөр газар нутаг руу цөлөгдөхөөс авахуулаад социалист нийгэмчлэлтэд хамрагдах хүртэл орчин үеийн ертөнцийн төрөл бүрийн үйл ажиллагаанд өртсөн билээ.

Тухайлбал, 1930-аад оны эхээр ЗХУ-ын бүрэлдхүүнд байсан Казакстаны нүүдэлч малчдыг хамтралжуулах, суурин амьдралд оруулах бодлогыг хүчээр явуулсан бөгөөд үүнд 550 мянган өрх хамрагдаж, газар тариалан битгий хэл мал аж ахай эрхлэх аргагүй тийм хуурай усгүй бүс нутагт шахагдаж байжээ. Үүний дүнд жишээ нь, 1928 онд 30 гаруй сая байсан Казакстаны малын тоо толгой 5-хан жилийн дотор 6 дахин хорогдож, хүн ам ч ихээхэн үрэгдсэн байна.(Khazanov, 1994:II)

Соёлын хувьсгалын явцад Хятадын засгийн газар мөн хамтралжуулах бүх нийтийн аян өрнүүлж, нүүдэлчдэд ихээхэн хохирол учруулсан баримт байдаг.

Монголын нүүдэлчид ч энэхүү үйл явцыг тойроогүй бөгөөд 1930-аад оны эх, 1950-иад онуудад хийсэн 2 удаагийн кампанит ажлын дүнд Монголын мал аж ахуй бүрэн нийгэмчлэгдэв. Харин нэг ялгаа нь гэвэл хүний амины гарз гараагүй юм.

Нүүдлийн мал аж ахуйг ийнхүү орчин үеийн хөгжлийн замд тээглэсэн саад тотгор хэмээн үзэх явдал дан ганц Коммунист улс орнуудад ч тохиолдож байсангүй. Иран улсад, Реза Шахын засаглалын үед бэлчээрийн мал аж ахуйг модернжилтийн зам дахь саад хэмээн зарлаж, нүүдэлч малчдыг хүчээр суурьшуулах бодлого явуулснаас мал сүргийнх нь 75 хувь сүйрч, Иран улс мах, сүү, түүхий эдийн гачигдалд орж байжээ.

Гэсэн хэдий ч нүүдэллэн аж төрөхүй орчин үеийн ертөнцийн нэлээд их бүс нутагт оршиж, хэдийгээр төрөл бүрийн өөрчлөлт хувиралыг дамжсан ч гэлээ өөрийн гэсэн өвөрмөц бүтцийг хадгалсаар л байна. XX зууны төгсгөл үеийн баримжаагаар нүүдэлчин хэмээгдэх ангилалд Ойрхи Дорнод, Төв ба Дотоод Ази (Central and Inner Asia), Африк болон Умард хязгаар (Far North)-ын нутагт ойролцоогоор нийтдээ 30 – 40 сая хүн хамаарагддаг аж.¹⁴⁰ (Khazanov, 1998: 7) Нигер, Жибоути ба Мавритани зэрэг Африкийн зарим оронд бэлчээрийн мал аж ахуй эрхлэгсэд хүн амын дийлэнхийг бүрдүүлэх бөгөөд нэгэн тооцоогоор бол дэлхийн бүх тэжээвэр малын ойролцоогоор 43% нь (үүнээс үхрийн 15, хонины 45, ямааны 45, тэмээний 97, адууны 14 хувь нь тус тус) нүүдэлчдийн гар дээр байдаг байна. (Myagmarjav, 1999: 99)

XX зууны төгсгөл дэх өөрчлөлтүүд хийгээд нүүдэлчид

1990-ээд онд одоогийн пост-коммунист орнуудад гарсан хувьсгалт шинжтэй өөрчлөлтүүд бол дан ганц Социализмын нурулт гэхээсээ илүүтэй, басхүү XX зуунд оргил үедээ гарсан модернизацийн үйл явц, технократ үзэл санааны, хүн төрөлхтний хөгжлийн замыг

¹⁴⁰ Гэхдээ судлаачдын дунд нүүдэлчин гэж хэнийг нэрлэх талаар маргаантай ойлголт байдгаас үүдэн дээрх тоо хэлбэлзэж болох юм. (Д.М)

“зааж” асан агуу их мета хүүрнэлүүдийн /metanarratives/ сааралт байсан гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, 1950-иад оны үеэс бий болж эхэлсэн хэмээн Францын нийгмийн онолч Ж.Лиотарын(2012) үзэж буй постмодерн соёлын шилжилтийн нэг дам үр дагавар байсан гэхэд хилсдэхгүй болов уу.

Социалист систем өөрийн агуу их “чөлөөлөгч, аврагч”-ийн үүргээ алдлаа. Агуу их баатрууд, агуу их дэвшилтэт анги – ажилчин анги, заан чиглүүлэгч агуу их үнэн өөрийн үүргээсээ чөлөөлөгдлөө. Түүний орыг амьдралын олон талт, жирийн бодит байдал, техник шинжтэй энгийн ашигт байдлууд эзэлж эхэллээ.

1990-ээд оны өөрчлөлтөөс Монголын малчин нүүдэлчдэд туссан анхны шууд үр дүн бол мал аж ахуйн бүрэн хувьчлал байсан юм.

1990-ээд оноос хойш ялангуяа хуучин социалист байсан улс орнуудын заримд бэлчээрийн мал аж ахуйд хандсан сонирхол ихээхэн хэмжээгээр сэргэсэн ба малчин өрхийн тоо нэмэгдэж, нүүдэллэн аж төрөхүйн хэв маяг бүхий өдөр тутмын социал амьдрал нь ч илэрхий сэргэж эхэлсэн байна. Тухайлбал Монгол улсад гэхэд, 1989 оны байдлаар улсын хэмжээнд нийт өрхийн 16.1 хувийг бүрдүүлж байсан малчин өрхийн тоо 1998 онд 35.0 хувь болж өссөн байна. (Монгол улсын статистикийн эмхэтгэл, 1999: 95)

Үүний дүнд тухайн үеийн хүн амын бараг гуравны нэг нь мал аж ахуй эрхлэх гэр бүлүүдэд хамаарагдаж, үүний ихэнх нь шууд, нүүдлийн гэгдэх аж төрөх ёсны хүрээнд амьдарч байлаа.

Нэг төрлийн “Renomadisation” хэмээн нэрлэж ч болох энэхүү үйл явцын учир шалтгаан дараахь хүчин зүйлстэй холбоотой байв.

1. Өмнө нь оршин тогтож асан социалист хүрээллийн улс орнууд дахь улс төрийн донсолгоонуудын нөлөөллөөр Монголд төрийн социализм нуран унаж, улс орон бүхэлдээ улс төр – эдийн засгийн шинэ бүтэц рүү шилжиж эхэлсэн
2. Дээрх ерөнхий шалтгааны улмаас улсын өмч байсан мал аж ахуйд бүрэн хувьчлал хийсэн
3. Удирдлагын социалист тогтолцоо өөрчлөгдсөнтэй (угтаа түр зуурын хаос байдалд орсны улмаас) холбоотойгоор, ялангуяа хөдөөгийн жижиг сум суурингуудад ажлын байр ба амьдралын тогтсон социал хэв ёс, тэнцвэр алдагдсаны улмаас мянга мянган хүн ажилгүй болж, амьдрахын тулд өөр шинэ сонголт хийхээс аргагүй байдалд орсон
4. Улмаар нийгмийн албан ёсны институт болон байгууллагуудын дийлэнх нь гэнэтийн бөгөөд эрс хатуу эргэлтэд өртсөн тэр цаг үе дэх хөдөөгийн хүн амын зарим хэсгийн хувьд мал аж ахуй эрхлэх нь амьжиргаагаа залгуулах илүү аятай, гарын дор хэрэгсэл мэт харагдаж байсан нь ч мөн нэгэн шалтгаан болон заагдаж болох юм.

Угтаа бол уламжлалт мал аж ахуй аль нэгэн улс оронд дахин сэргэх явдал нь өнөөгийн дэлхий ертөнцөд тогтвортой удаан үргэлжлэх хандлагатай биш харин төвлөрсөн хүчний сулралт зэргийн цаг зуурын хүчин зүйлстэй илүү холбоотой болохыг тэмдэглэгсэд (Khazanov, 1998: 12) байдаг ч, Монгол дахь хамгийн багадаа л сүүлийн арав хорин жилийн доторхи нийгмийн үйл явцыг ажиглахад л, тийм ч амархан сарних шинжтэй биш гэдэг нь харагдаж байна. Цаг хугацааны явцад буцах хөдөлгөөн явагдлаа ч гэсэн ялангуяа Монголын хувьд энэхүү “Renomadisation”-ы ардаа орших ул мөрийн социал цар хүрээ тийм ч багаар хэмжигдэхээргүй нь тодорхой.

Дүгнэлт

Нүүдэлчид нь өөрийн түүхэнд, байгаль цаг ууурын болоод өөрсдийн үйл ажиллагааны улмаас гэхээсээ илүүтэй, /цагийн эрхээр хөгжлийн концепцийн эсрэг байранд тавигдаж/ тухайн цаг үе нь, хүчний засаглал нь уг соёлыг хэрхэн харж байснаас хамааран хамгийн их хохирлыг амсаж байсан бөгөөд үүнийг ялангуяа XX зууны ЗХУ-ын бүрэлдхүүнд багтаж асан Түрэг гаралтай нүүдэлчин угсаатнууд, тухайлбал Казакстаны нүүдэлчдийн түүх харуулна.

XX – XXI зууны зааг үе нь ялангуяа Монголчуудын нүүдэллэн аж төрөх ёс, түүний соёлын үнэт зүйлийн хувьд таатай нэгэн цаг үеийг авчирсан гэж үзэж болно.

Үүнд дараахь нөхцөл байдлуудын хам нөлөө тусгалаа олжээ.

1. Модернизацийн тэргүүлэх үзэл санааг дагалдсан соёл ба үнэлэмжийн зарим сөрөг хандлага, дам ба шууд нөлөөллүүд суларсан
2. Хөгжлийг үзэх хувьслын болон ашигч, технократ /капиталист, социалист ялгаагүй/ үзэл баримтлал хүчинт чанараа алдаж эхэлсэн
3. Социализм тогтолцооны хувьд нуран унаснаар дэлхийн хэт том хүчнүүдийн блокчлол задарч, олон талт байдалд шилжсэн

4. Байгаль экологийн асуудлууд хүн төрөлхтний хөгжлийн сүүлийн 400 гаруй жилийн турш явж ирсэн загвар, амьдралыг үзэх үзэлд шинэ асуултуудыг тавьж эхэлсэн
5. Технологийн, тэр тусмаа мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил нь нүүдэлч малчдын хувьд хот суурин газрынхнаас дутахгүйгээр мэдлэг мэдээлэл авах, соёлжиж боловсрох нэн таатай боломжийг бий болгож, 1000 жилийн өмнөх мал маллагааны арга технологи, аж төрөх ёс, амьдралын хэв маяг XXI зууны эхэн үеийн, тэр дундаа постмодерн соёлын нөхцөлтэй харшилдахгүйгээр барахгүй харин ч бүр эвсэлдэн найрч болох шинэ загварын санааг бидэнд өгч байна. Харин шинэ цагийн нүүдэлчдийн өөрчлөлт хөгжил, уламжлалт соёлын асуудал нь зөвхөн тэдний өөрсдийнх нь асуудал биш, Монголын засаг төр, олон нийт, судлаачид хийгээд дэлхийн соёлын өвийг хамгаалах чиг үүрэг бүхий ЮНЕСКО-гийн ч хүртэл асуудал мөн юм.

НОМ ЗҮЙ

1. ABU-LUGHOD, Janet (1989) Before European Hegemony: The World System A. D 1250-1350. New York : Oxford Univeslty Press
2. HALL. Thomas D. (1991) "Civilizational Change: The Role of Nomads." Comparative Civilizations Review, 24 Spring
3. HUMPHREY, Caroline and David Sneath (1999) The End of Nomadism?: Society, State and the environment in inner Asia. Duke University Press, Durham: Nc
4. İBN-HALDUN (1997) Mukaddime (1) İstanbul: M.E.B
5. KHAZANOV, Anatoly M. (1995) Nomads and The Outside World. (Tranl. Julia Crookenden) Wisconsin: The University of Wisconsin Press.
6. KHAZANOV, Anatoly M. (1998) "Pastoralists in the Contemporary World: The Problem of Survival." Changing Nomads in a Changing World. (Ed.) Joseph Ginat and Anatoly Khazanov. Portland, Or: Sussex Academic Press.
7. КРАДИН, Н.Ф (1992) Кочевые общества. Владивосток: Дальнаука
8. LANCASTER, W, ve F. Lancaster (1998) "Who are these Nomads? What are they do? Continuous Change or Changing Continuities?" Changing Nomads in a Changing World. (Ed.) Joseph Ginat and Anatoly Khazanov. Portland Or.: Sussex Academic Press.
9. LİGETİ, L. (1997) Bilinmeyen İc Asya (Cilt 1) İstanbul: M.E.B
10. ЛИОТАР, Жан-Франсуа (2012) Постмодерн нөхцөл: Мэдлэгийн тухай тайлан. Улаанбаатар: ФТ
11. Монгол улсын статистикийн эмхэтгэл – 1998 (1999) Улаанбаатар:ҮСГ
12. MYAGMARJAV, B. (1999) "Some of the Major problems of the World Nomads and Seminomadic Livestock Husbandry " International Symposium on 'Nomads and Use of Pastures Today." Collection of Abstracts. Ulaanbaatar: International Institute for the Study of the Nomadic Civilizations. Ulaanbaatar
13. SEZER, Baykan (1979) Asya Tarihinde Su Boyu Ovaları ve Bozkır Uygarlıkları İstanbul: Edebiyat Fakultesi Basımevi
14. SOROKİN, Pitirim A. (1997) Bir Bunalım Çağında Toplum Felsefeleri İstanbul: Gocebe Yayınları
15. WEBER, Max (1993) Sosyoloji Yazıları. İstanbul: Hurriyet Vakfi Yayınları.
16. ШНИРЕЛЬМАН, В.А. (1986) "Позднепервобытная община земледельцев-скотоводов и высших охотников, рыболовов и собирателей." История первобытного общества (Ред.) Ю.В.Бромлей. Москва: Наука